



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО




БАРИЛГА 2024

Улаанбаатар хот
2025 он



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

БАРИЛГЫН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА, 2024 ОН



Улаанбаатар хот
2025 он

ТАНИЛЦУУЛГЫГ БЭЛТГЭН БОЛОВСРУУЛСАН:

Х.Тэмүүлэн

ҮСХ-ны ЭЗСГ-ын ХААБОҮСХ-ийн статистикч

ТАНИЛЦУУЛГЫГ ХЯНАСАН:

Б.Батдаваа

ҮСХ-ны дарга

Д.Лхамсүрэн

ҮСХ-ны дэд дарга

Ц.Тэгшжаргал

ҮСХ-ны НэСГ-ын дарга

М.Оюунжаргал

ҮСХ-ны ЭЗСГ-ын дарга

Э.Мягмарханд

ҮСХ-ны ЭЗСГ-ын ХААБОҮСХ-ийн дарга

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Монгол Улс, Улаанбаатар хот
Засгийн газрын III байр,
Бага тойруу - 44, Улаанбаатар -11
Утас: (976-11)-261502, 7014-1212
Факс: (976-11)-261502
Цахим хуудас: www.1212.mn
И-мэйл: information@nso.mn

АГУУЛГА

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	2
ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ	2
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ	3
ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ	4
ХАМРАХ ХҮРЭЭ	6
БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ТҮҮХ	7
I. БАРИЛГЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ	9
I.1 БАРИЛГЫН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ЭЗЛЭХ БАЙР, СУУРЬ	9
I.2 БАРИЛГЫН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО	9
I.3 БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧИД	11
I.4 БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН	11
I.5 БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ	12
I.6 БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	12
I.7 БАРИЛГЫН САЛБАРЫН ОСОЛ	13
II. БАРИЛГА УГСРАЛТ ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ	15
III. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД	19
III.1 АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА	19
III.1.1 ИПОТЕКИЙН ЗЭЭЛ	19
III.2 АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГА	21
III.3 МОНГОЛ УЛСЫН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭ	22
IV. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ	25
IV.1 ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ	25
IV.2 ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГ ДЭХҮҮНИЙ ҮНЭ	26
V. БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС	27
VI. ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС	28
VII. ДҮГНЭЛТ	30
АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ	31
ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД	32

ХҮСНЭГТЭН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ХҮСНЭГТ 1. АЖИЛЛАГЧИД, нас, хүйсээр, мянган хүн.....	11
ХҮСНЭГТ 2. ОСОЛДОГЧИД, салбараар, мянган хүн.....	13
ХҮСНЭГТ 3. МОНГОЛ УЛСЫН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭ, ангиллаар	22
ХҮСНЭГТ 4. ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС.....	28
ХҮСНЭГТ 5. ОРОН СУУЦНЫ 1 МЕТР КВАДРАТ ТАЛБАЙН ДУНДАЖ ҮНЭ, оны эцэст	29

ЗУРГАН МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

ЗУРАГ 1. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САЛБАРЫН БҮТЭЦ.....	9
ЗУРАГ 2. БАРИЛГЫН САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО, мянган ААНБ	10
ЗУРАГ 3. БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ЭЗЛЭХ ХУВЬ, бүсээр..	10
ЗУРАГ 4. АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, мянган төгрөгөөр	11
ЗУРАГ 5. БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг	12
ЗУРАГ 6. БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, тэрбум төгрөгөөр.....	12
ЗУРАГ 7. БАРИЛГЫН САЛБАРТ ОСОЛДСОН ХҮНИЙ ТОО	13
ЗУРАГ 8. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, тэрбум төгрөгөөр	15
ЗУРАГ 9. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, улирлаар, тэрбум төгрөгөөр	15
ЗУРАГ 10. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувь, 2024 он.....	16
ЗУРАГ 11. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр, дүнд эзлэх хувь... 16	
ЗУРАГ 12. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, бүсээр, хувиар	17
ЗУРАГ 13. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД, барилгын төрлөөр, хувиар, 2024 он.....	19
ЗУРАГ 14. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, айлын тоо, өртгөөр	19
ЗУРАГ 15. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА, ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ТОО	20
ЗУРАГ 16. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, айлын тоогоор, аймгаар.....	20
ЗУРАГ 17. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН СУРГУУЛЬ, СОЁЛЫН БАРИЛГА, суудлаар.....	21
ЗУРАГ 18. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ЭМНЭЛЭГ, орны тоогоор	21
ЗУРАГ 19. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН АВТО ЗАМ, км	22
ЗУРАГ 20. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ГҮҮР, ГҮҮРЭН ГАРЦ, метр.....	23
ЗУРАГ 21. ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ, мян.тн	25
ЗУРАГ 22. БАРИЛГЫН БЛОКИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ, мян.тн.....	25
ЗУРАГ 23. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ.....	26
ЗУРАГ 24. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ЖИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ	27
ЗУРАГ 25. БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС (2015=100), улирлаар, хувиар.....	28
ЗУРАГ 26. ОРОН СУУЦНЫ 1 МЕТР КВАДРАТ ТАЛБАЙН ДУНДАЖ ҮНЭ, мянган төгрөгөөр.....	29

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
БР	Статистикийн бизнес регистрийн сан
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ЗТХЯ	Зам тээврийн хөгжлийн яам
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
МИК	Монголын ипотекийн корпорац
ЭЗБТУАСА	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал
ОУНОШБ	Олон Улсын нисэх онгоцны шинэ буудал
БУИЗА	Барилга угсралт, их засварын ажил

Тэмдэглэгээ

*	Урьдчилсан гүйцэтгэл
м ²	Метр квадрат
м ³	Метр куб
...	Гүйцэтгэл байхгүй

ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Барилгын салбарын статистикийн үзүүлэлтүүдийг тооцоход дараах ойлголт, тодорхойлолтуудыг ашигладаг. Үүнд:

Барилгын үйл ажиллагаа гэж байгууламжийн зураг төсөл, баримт бичиг боловсруулах, магадлал хийх, барилгын ажил гүйцэтгэх, үе шатны ажилд хяналт тавих, чанар аюулгүй байдлын шинжилгээ хийх, ашиглалтад оруулж, гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг ойлгоно.

Барилга байгууламжид орон сууц, иргэн, үйлдвэр, эрчим хүч, харилцаа холбоо, ус, нефтийн барилга, ус суваг, далан хаалт зэрэг байгууламж, түүний инженерийн шугам сүлжээг хамруулж ойлгоно.

Орон сууцны барилга гэж нийт ашигтай талбайг бүхэлд нь эсвэл нийт ашигтай талбайн талаас илүү хувийг орон сууцны зориулалтаар (үлдсэн хувийг өөр зориулалтаар ашиглаж болохуйц байж болно.) хэрэглэж болохуйц байгууламжийг хамруулж ойлгоно. Орон сууцны барилгыг энгийн орон сууц, үйлчилгээтэй орон сууц, гарааштай орон сууц, гарааш, үйлчилгээтэй орон сууц гэж ангилж авч үзнэ. Энэ төрлийн барилгад нэг гэр бүл болон олон гэр бүл амьдарч болохуйц нийтийн сууц, сууцны бие даасан барилга, амины сууц, зарим хэсэг нь худалдаа, үйлчилгээний зориулалттай орон сууцны барилга зэрэг багтана.

Орон сууцны бус барилга гэж тухайн байгууламжийн нийт ашигтай талбайг бүхлээр нь орон сууцны бус зориулалтаар ашиглаж болохуйц эсвэл нийт ашигтай талбайн талаас илүү хувийг орон сууцны бус зориулалтаар ашиглаж болохуйц байгууламжийг ойлгоно. Орон сууцны бус барилгыг үйлдвэрийн, худалдаа, үйлчилгээний, зочид буудлын, эмнэлгийн, сүм хийдийн, сургууль, соёлын, цэцэрлэгийн, спорт, биеийн тамирын, албан конторын, орон сууцны бус бусад (агуулах, гарааш болон бусад) гэж ангилна.

Инженерийн барилга, байгууламж гэж төмөр зам, зам, гүүр, хурдны зам, онгоцны буудлын талбай, усан хангамж, бохирын шугам, далан хаалт, усжуулалтын байгууламж зэрэг барилга угсралтад ангилагддаггүй барилга, байгууламжийн бүх ажлыг хамруулж ойлгоно. Инженерийн байгууламжийг эрчим хүчний, холбооны, төмөр зам, хатуу болон хайрган хучилттай авто зам, сайжруулсан хөрсөн зам, ердийн хөрсөн зам, төмөр бетон гүүр, гүүрэн гарц, модон гүүр, гүүрэн гарц, далан суваг, шугам, бусад зам талбайн ажил гэж ангилна.

Инженерийн дэд бүтэц нь авто зам, төмөр зам, дүүжин зам, газрын доор, дээр байрлах замын байгууламж, бүх төрлийн инженерийн шугам сүлжээ, гамшиг, ослоос урьдчилан сэргийлэх энгийн болон инженерийн хийц, бүтээц бүхий байгууламж юм.

Инженерийн шугам, сүлжээ нь ус хангамж, цахилгаан, дулаан, ариутгах татуурга, цэвэрлэх байгууламж, газрын тос болон төрөл бүрийн хий дамжуулах хоолой, харилцаа холбооны төвлөрсөн байгууламж юм.

Барилга угсралт, их засварын ажил гэж барилга, байшин барих болон инженерийн зориулалтаар зам, гүүр, далан зэрэг инженерийн бусад байгууламжийг барих хэлбэрээр үндсэн хөрөнгийг бий болгох, шинэчлэх, засварлах, өргөтгөхөд чиглэсэн үйл ажиллагааг хамруулж ойлгоно. Их засварын ажилд орон сууцны болон орон сууцны бус барилга, инженерийн барилга байгууламжид хийгдэх бүх төрлийн засварын ажлыг хамруулж ойлгоно.

Буулгалтын ажил гэж ашиглалтын шаардлага хангахгүй болсон, хууль тогтоомж, барилга байгууламжийн норм, нормативын баримт бичгийн шаардлагыг ноцтой зөрчиж баригдсан нь эрх бүхий байгууллагаас тогтоогдсон барилга байгууламжийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн буулгах үйл ажиллагааг ойлгоно.

Гадна тохижилтын ажил гэж барилга байгууламжийн гаднах талбайн ногоон байгууламж, авто зам, зогсоол, явган хүний зам, гарц, оршин суугчдын амрах болон хүүхдийн тоглоомын талбай, уран барилгын жижиг хэлбэр, гэрэлтүүлэг зэргийг барьж байгуулах үйл ажиллагааг ойлгоно.

Үе шатны ажил гэж барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах, барилгын ажил гүйцэтгэх, ашиглалтад оруулах үйл ажиллагаа тус бүрийн технологийн дараалал юм.

Барилгын ажлын гүйцэтгэгч гэж захиалагчтай гэрээ байгуулсны үндсэн дээр барилгын ажлыг гүйцэтгэх эрх бүхий хуулийн этгээд юм. Барилгын ажлыг гүйцэтгэгч ААНБ-ыг өмчийн хэлбэрийн хувьд дотоод, гадаадын гэж ангилах бөгөөд дотоодын ААНБ-ыг хувийн, төрийн, гадаадтай хамтарсан гэж ангилна.

Барилгын ажлын захиалагч гэж барилга байгууламжийн барилгын ажил гүйцэтгүүлэх сонирхол бүхий иргэн, хуулийн этгээд болон тэдгээрийн итгэмжлэгдсэн төлөөлөгч юм.

Туслан гүйцэтгэгч гэж тухайн барилга байгууламж (объект)-ийн тодорхой үе шатны ажилд үндсэн гүйцэтгэгчийн чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий ААНБ юм. Тухайн объектод хэдэн ч туслан гүйцэтгэгч ажиллаж болно.

Барилгын хөрөнгө оруулагч гэж барилга байгууламжийг барихад шаардагдах хөрөнгийг санхүүжүүлсэн иргэн, хуулийн этгээд юм.

Ашиглалтад оруулсан үндсэн фонд гэж барилга байгууламж, объект баригдаж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд хийгдсэн бүх өртгийн нийлбэр дүн юм.

Тайлант оны гүйцэтгэл гэж барилга (объект)-д тухайн оны улирал бүрт хийгдсэн барилга угсралт, их засварын ажлын нийт өртгийн нийлбэр юм.

Барилга эхэлснээс хойших гүйцэтгэл гэж тухайн барилга (объект)-д анх баригдаж эхэлснээс хойш тайлант хугацаа хүртэл хийгдсэн барилга угсралтын бүх ажлын өртгийн нийлбэр юм.

Төсөвт өртөг гэж барилгын зураг төслийн баримт бичгийг үндэслэж тооцсон, барилга барихад шаардагдах нийт мөнгөн хөрөнгийн нийлбэр юм. Төсөвт өртөг нь тухайн барилга (объект) баригдах явцад өөрчлөгдөж болно.

Барилга байгууламжийг засварлах, тоноглох гэж ашиглалтын хэвийн нөхцөлийг дээшлүүлэх зорилгоор барилга байгууламжийг бүхэлд нь буюу хэсэгчлэн засварлаж, нэмэлт болон тусгай тоног төхөөрөмж суурилуулах үйл ажиллагааг ойлгоно.

Барилга байгууламжийг өргөтгөх шинэчлэх гэдэгт барилга байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн үндсэн бүтээц болон инженерийн шугам сүлжээг өөрчлөх, өргөтгөл, шинэчлэл хийх үйл ажиллагааг оруулна. Барилга байгууламж шинээр барих гэдэгт барилга байгууламж барих, эсхүл хуучин барилга байгууламжийг буулгаж барих үйл ажиллагааг ойлгоно.

Бие даасан эх үүсвэр, шугам, сүлжээ гэж тухайн барилга байгууламжийн хэрэгцээг хангахад зориулан барих ус, дулаан, уур, хий, цахилгаан, харилцаа холбоо зэрэг инженерийн хангамжийн шугам сүлжээ, байгууламжийг хамруулж ойлгоно.

Объект гэж бие даасан барилга (орон сууц, үйлдвэрийн гол корпус, сургууль, цех, агуулах) буюу байгууламж (зам, гүүр, далан, суваг, нүхэн гарц) түүнтэй холбогдож хийгдэх үндсэн ба туслах чанарын бусад байгууламж, гадна инженерийн бүх төрлийн шугам сүлжээ, хийц тоноглол, барилгын талбайд хийгдэх өндөржилт, тохижилтын ажлыг хамруулна. Барилга байгууламж, объектын улирлын мэдээнд объект нь нутаг дэвсгэрийн зарчмаар буюу тухайн нутаг дэвсгэрийнхээ барилга угсралт, их засварын ажлын нийт дүнд орж тооцогдоно.

Барилгын материал гэдэгт стандарт, эрүүл ахуй, экологийн шаардлагыг хангасан барилга байгууламжид хэрэглэгдэх эрдэс, түүхий эд, материал, бүтээц, бүтээгдэхүүн, эдлэхүүнийг хамруулж ойлгоно.

ХАМРАХ ХҮРЭЭ

Барилгын салбарын хамрах хүрээ нь Монгол Улсын нутаг дэвсгэрт барилгын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа өмчийн бүх хэлбэрийн ААНБ байна.

Барилгын салбарт эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал (ISIC 4.0)-ын дагуу барилга угсралт, барилгын инженерчлэлийн үйл ажиллагаа, барилгын тусгай үйл ажиллагаа гэсэн 3 дэд салбар хамаарна.

Барилга угсралт, их засварын ажлыг тооцохдоо улирал бүрт гүйцэтгэсэн барилга угсралт их засварын ажлын гүйцэтгэлийн нийт дүнгээр тооцдог бөгөөд ашиглалтад оруулсан үндсэн фонд нь барилга байгууламж (объект) баригдаж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд зарцуулсан нийт өртгийн хэмжээгээр тодорхойлогдоно.

Барилга байгууламж (объект) нь тайлант онд ашиглалтад орсон бол тухайн тайлант онд хийгдсэн барилга угсралт, их засварын ажлыг тооцохдоо ашиглалтад оруулсан үндсэн фондоос өмнөх онуудад хийгдсэн БУИЗА-ын дүнг хасаж тооцно.

Барилга угсралт, их засварын ажлын бүтцийг тооцохдоо барилга угсралт, их засварын ажлыг төрлөөр нь орон сууцны, орон сууцны бус, инженерийн байгууламж, их засварын ажил гэж ангилна. Төрөл тус бүрийн ажлын өртгийн дүнг нийт дүнд эзлэх хувиар тооцож байна. Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг тооцох мэдээллийн эх үүсвэр нь бизнес регистрийн санд бүртгэлтэй барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллагын тайлант хугацаанд гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын хэмжээ болон холбогдох бусад эх үүсвэр буюу ХББОСЯ-ны ашиглалтад оруулсан барилга, байгууламж, барилга барих эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл авсан байгууллагын жагсаалттай тулган шалгах үйл явц болно. Мэдээллийг жилийн болон улирлын давтамжтайгаар цуглуулж холбогдох тооцооллыг хийдэг.

Жилийн давтамжтайгаар: Тайлант хугацаанд статистикийн бизнес регистрийн санд бүртгэлтэй, барилгын салбарын 41-43 дахь дэд салбарт хамаарах үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тооны нийлбэрээр тодорхойлогдоно.

Аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааны дэлгэрэнгүй мэдээ, Аж ахуйн нэгж байгууллагын хураангуй мэдээ гэсэн маягтаар тухайн ААНБ-ын орлого, зарлагын дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулан барилгын салбарын нэмэгдэл өртгийг тооцож байна.

Жилийн мэдээнд барилгын салбарт далд эдийн засгийн үйл ажиллагааг тооцох зорилгоор барилгын салбарт хувиараа хөдөлмөр эрхлэгчид, иргэдийн үйл ажиллагааг нэмж тооцдог.

Улирлын давтамжтайгаар: Тайлант хугацаанд аймаг, нийслэл, сум, дүүргийн нутаг дэвсгэрт баригдаж буй барилга байгууламж, объектын (ББО-1) мэдээг гүйцэтгэгч ААНБ, захиалагч ААНБ-аас тухайн улирлаар болон өссөн дүнгээр гүйцэтгэлийг цуглуулдаг. Барилга байгууламж, объектын төрлөөр болон гүйцэтгэгч ААНБ-ын өмчийн хэлбэрээр гүйцэтгэлийг тооцдог.

БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨГЖЛИЙН ТҮҮХ

Манай улс барилга, байгууламж тоног төхөөрөмжийн тооллогыг 1926, 1927, 1930 онд хүн ам, малын тооллоготой хамт явуулж байжээ. Хошуу, жасын үл хөдлөх хөрөнгийн 1926 оны тооллогоор 30 гаруй мянган орон байшин тоологдсон байна.

Монголын хувь нийлүүлсэн барилгын хоршоо, хувь нийлүүлсэн “Монгол транс” нийгэмлэгийн харьяанд 1926 онд зам, барилгын ажлыг гүйцэтгэх ерөнхий газар, мал аж ахуйн яамны дэргэд 1929 онд худаг усны хайгуул, барилгын ажлыг эрхэлсэн усан хангамжийн салбар, аж үйлдвэр, барилгын яамны харьяанд 1938 онд барилгын үйлдвэрлэлийг эрхлэн гүйцэтгэх трест, мөн аж ахуйн аргаар барилгын ажил гүйцэтгэгч, захиалагчийн газар 1937 онд байгуулагдсанаар эдгээр салбарт барилгын статистикийн нэгж бий болсон байна.

Барилгын бүртгэлийн ажилд 1960-аад оноос эхлэн ахиц гарч, барилгын захиалагч, гүйцэтгэгч, зураг төсвийн байгууллагын төлөвлөгөөт зорилтын биелэлтэд тогтмол хяналт тавих программын үндсэн дээр зохион байгуулалттай статистик ажиглалтыг явуулах бололцоо, нөхцөл бүрджээ. БНМАУ-ын сайд нарын зөвлөлийн 1961 оны 636 дугаар тогтоолоор барилгын байгууллагын улсын чанартай тайлан мэдээг яам, тусгай газрууд өөрийн системээр нэгтгэж, Тоо бүртгэлийн улсын төв газарт ирүүлж байсан журмыг өөрчлөн, аймаг, хотын статистикийн товчоодоор дамжуулан Тоо бүртгэлийн улсын төв газарт мэдээлж байх журам тогтоосноор нэгдсэн системд орсон.

Төрөөс 1988 оноос их барилга, хөрөнгө оруулалтын салбарт ихээхэн анхаарал хандуулж, төвлөрсөн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулах үүднээс олон тооны нарийвчилсан, дэлгэрэнгүй үзүүлэлтээр мэдээлэл цуглуулж, боловсруулалт хийдэг байсан. Тухайлбал: хөрөнгө оруулалт, ашиглалтад оруулсан үндсэн фондын төлөвлөгөөний биелэлтийн жилийн тайлангаар хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг технологийн бүтцээр, улс ардын аж ахуйн салбараар ангилан гаргаж байв.

Монгол Улс ардчилсан зах зээлийн харилцаанд шилжиж, парламентын засаглалтай, ардчилсан нийгмийн байгуулал төлөвшиж, өмчийн олон хэлбэрийн аж ахуйн нэгжүүд бий болсон. 1992 он хүртэл хөрөнгө оруулалтын өсөлт тогтвортой байсан бол 1993 оноос эдийн засгийн уналт, төсвийн хомсдлоос болж барилга угсралтын ажил, машин тоног төхөөрөмжид оруулсан хөрөнгө оруулалт буурч, зогсонги байдалд орсон.

2000 он гарсаар манай улсын эдийн засгийн орчин сайжирч, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээ нэмэгдэхийн хэрээр үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, үүний дотор барилгын салбарын үйлдвэрлэлийн хэмжээ тогтмол өсөж, барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2000 онд 77.1 тэрбум төгрөг, 2010 онд 463.0 тэрбум төгрөг, 2021 онд 5.1 их наяд төгрөг, 2022 онд 6.8 их наяд төгрөг, 2023 онд 8.0 их наяд төгрөг, 2024 онд 9.2 их наяд төгрөгт хүрээд байна. Мөн 2012 онд төрөөс барилгын салбарыг дэмжих бодлого хөтөлбөр хэрэгжүүлснээр гэр хорооллыг дахин төлөвлөж, хүн амыг орон сууцжуулах ажлыг эхлүүлсэн нь барилгын салбар эрчимтэй өсөхөд нөлөөлж байна.

Түүнчлэн Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг, Хөшигтийн хөндийд 2016 оноос ОУНОШБ-ын барилга, түүнийг дагасан бүтээн байгуулалтууд, Өмнөговь, Дорноговь аймгуудад 2019 оноос эхлэн Тавантолгой-Гашуун сухайт чиглэлийн 208.5 км, Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 414.6 км төмөр зам, “Тавантолгой-Гашуунсухайт” чиглэлийн 208.5 км төмөр замын ажил, 2024 онд “Зүүнбаян-Ханги” чиглэлийн 226.9 км төмөр зам, “Шивэ хүрэн-Сэхэ” чиглэлийн 19.3 км төмөр замын ажил, Улаанбаатар-Дархан-Уул чиглэлийн авто зам, гэх мэтчилэн эрчим хүч, төмөр зам, авто замын томоохон инженерийн барилга, байгууламжийн бүтээн байгуулалтын ажлууд хийгдэж, ашиглалтад орсон байна. Мөн Бөөрөлжүүтийн цахилгаан станц, хоногт 250 мянган метр куб бохир ус хүлээн авч цэвэрлэх хүчин чадал бүхий төв цэвэрлэх байгууламж, Оюу толгойн далд уурхайн бүтээн байгуулалтын ажил, төмөр зам болон авто замын ажлууд, орон сууцны барилгын ажлууд эрчимтэй явагдсан байна.

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО,
ДУНДАЖ ЦАЛИН, ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ
2024 он

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ТОО

НИЙТ АЖИЛЛАГЧИД,
мянган хүн



АЖИЛЛАГЧДЫН ДҮНД
ЭЗЛЭХ ХУВЬ

93.2

6.9

ДУНДАЖ ЦАЛИН

УЛСЫН ДУНДАЖ
ЦАЛИН, мянган төгрөг



БАРИЛГЫН САЛБАРЫН
АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ
ЦАЛИН, мянган төгрөг

2 332.4

2 166.0

БАРИЛГЫН САЛБАРЫН АЖИЛЛАГЧДЫН ХӨДӨЛМӨРИЙН
БҮТЭЭМЖ

ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ,
улсын хэмжээнд, сая төгрөг



ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ,
барилгын салбар, сая төгрөг

22.6

11.0

БАРИЛГЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ

НИЙТ ОСОЛДОГЧИД



ҮҮНЭЭС: ЭМЭГТЭЙ

67


5

I. БАРИЛГЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

I.1 БАРИЛГЫН САЛБАРЫН ЭДИЙН ЗАСАГТ ЭЗЛЭХ БАЙР, СУУРЬ

Монгол улсын дотоодын нийт бүтээгдэхүүн (үйлдвэрлэлийн аргаар тооцсон) 2024 онд оны үнээр 80.0 их наяд төгрөг, 2015 оны зэрэгцүүлэх үнээр 32.1 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос оны үнээр 13.5 хувиар, зэрэгцүүлэх үнээр 4.9 хувиар тус тус өссөн байна. Барилгын салбар нь нийт дотоодын нийт бүтээгдэхүүний 3.7 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 1. ДОТООДЫН НИЙТ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ САЛБАРЫН БҮТЭЦ




Барилгын салбарын нэмэгдэл өртөг оны үнээр 2.6 их наяд төгрөг, зэрэгцүүлэх үнээр 1.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос оны үнээр 335.9 (14.8%) их наяд төгрөгөөр, зэрэгцүүлэх үнээр 28.0 (10.4%) их наяд төгрөгөөр тус тус өссөн байна.

I.2 БАРИЛГЫН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО¹

Статистикийн бизнес регистрийн санд 2024 онд 261.2 мянган аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байгаагийн 108.4 (41.5%) нь үйл ажиллагаа явуулж байна. Барилгын салбарт 2024 онд 18.3 мянган ААНБ бүртгэлтэй байгаагаас 8.6 (46.9%) мянган ААНБ нь үйл ажиллагаа явуулж байна. Манай улсад үйл ажиллагаа явуулж байгаа нийт ААНБ-ын 7.9 хувь нь барилгын салбарт байна.

¹ Эх үүсвэр: Бизнес регистрийн сан, ҮСХ


2. БАРИЛГЫН САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО, мянган ААНБ



Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо өмнөх оноос 268 (3.2%) -аар өссөн байна. Сүүлийн жилүүдэд хотжилт, хүн амын төвлөрөл, Засгийн газрын болон гадаадын хөрөнгө оруулалт, дэмжлэг, үл хөдлөх хөрөнгийн зах зээл өргөжих, дотоодын барилгын материалын үйлдвэрлэл нэмэгдэх зэрэг нь тус салбарт үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын тоо тасралтгүй өсөхөд нөлөөлж байна.

Барилгын салбарт үйл ажиллагаа явуулж байгаа нийт 8.6 мянган ААНБ-ын 7.0 (82.2%) мянга нь Улаанбаатар хотод, 358 (4.2%) нь Баруун бүсэд, 560 (6.5%) нь Хангайн бүсэд, 454 (5.3%) нь Төвийн бүсэд, 153 (1.8%) нь Зүүн бүсэд үйл ажиллагаа явуулж байна. Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ-ын дийлэнх нь Улаанбаатар хотод төвлөрсөн хэвээр байна.

ЗУРАГ 3. БАРИЛГЫН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААНБ-ЫН ЭЗЛЭХ ХУВЬ, бүсээр



I.3 БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧИД

Улсын хэмжээнд 15 ба түүнээс дээш насны ажиллагчдын тоо 2024 оны байдлаар 1355.7 мянга байгаагийн 93.2 (6.9%) мянга нь барилгын салбарт ажиллаж байна. Барилгын салбарын ажиллагчдын тоо өмнөх оноос 11.1 (13.5%) мянгаар өсчээ. Салбарын ажиллагчдын 16.1 (17.3%) мянган нь эмэгтэй, 77.0 (82.7%) мянган нь эрэгтэй байна. Нийт ажиллагчдын 44.1 хувь нь 15-34 насны, 49.6 хувь нь 35-54 насных байна. Ажиллагчдын дунд 35-54 насныхан зонхилсон хэвээр байна.

ХҮСНЭГТ 1. АЖИЛЛАГЧИД, нас, хүйсээр, мянган хүн

Он	Хүйс	Улсын дүн	Барилга	Насны бүлгээр			Нийт ажиллагчдад барилгын салбарт ажиллагчдын эзлэх хувь
				15-34	35-54	55+	
				2020	Бүгд	1 249.6	
	Эмэгтэй	578.4	11.4	5.1	6.2	0.2	2.0
	Эрэгтэй	671.3	69.0	35.7	30.6	2.7	10.3
2021	Бүгд	1 208.0	87.8	43.6	39.9	4.2	7.3
	Эмэгтэй	550.5	18.4	6.9	11.2	0.3	3.3
	Эрэгтэй	657.5	69.4	36.7	28.8	4.0	10.6
2022	Бүгд	1 283.1	82.5	36.4	39.9	6.3	6.4
	Эмэгтэй	592.7	14.1	6.0	7.6	0.5	2.4
	Эрэгтэй	690.5	68.4	30.4	32.3	5.7	9.9
2023	Бүгд	1 294.7	82.1	36.4	39.5	6.2	6.3
	Эмэгтэй	594.5	13.2	5.7	6.3	1.2	2.2
	Эрэгтэй	700.3	68.9	30.7	33.2	4.9	9.8
2024	Бүгд	1 355.7	93.2	41.1	46.3	5.8	6.9
	Эмэгтэй	618.9	16.1	6.0	8.3	1.8	2.6
	Эрэгтэй	736.8	77.0	35.1	37.9	4.0	10.5

Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа


I.4 БАРИЛГЫН САЛБАРТ АЖИЛЛАГЧДЫН ДУНДАЖ ЦАЛИН

Аж ахуйн нэгж, байгууллагын ажиллагчдын сарын дундаж цалин улсын хэмжээнд 2024 онд 2332.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 450.6 (23.9%) мянган төгрөгөөр нэмэгджээ.

Барилгын салбарт ажиллагчдын дундаж цалин улсын хэмжээнд 2166.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 347.5 (19.1%) мянган төгрөгөөр өссөн байна.

Барилгын салбарын ажиллагчдын сарын дундаж цалин нь улсын дунджаас 166.4 (7.1%) мянган төгрөгөөр бага байна.


ЗУРАГ 4. АЖИЛЛАГЧДЫН САРЫН ДУНДАЖ ЦАЛИН, мянган төгрөгөөр



1.5 БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ

Бүтээмж нь салбарын үр ашигтай байдлыг илэрхийлэх чухал үзүүлэлтийн нэг юм. Барилгын салбарын нэг ажиллагчид ногдох бодит ДНБ, 2024 онд 11.0 сая төгрөг болж, өмнөх оноос 0.3 (2.2%) сая төгрөгөөр буурчээ.

ЗУРАГ 5. БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨДӨЛМӨРИЙН БҮТЭЭМЖ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр, сая төгрөг




Барилгын салбарын хөдөлмөрийн бүтээмж нь улсын түвшнээс 51.4 хувиар доогуур байна. Сүүлийн 5 жилийн хугацаанаас харвал, 2020 онд салбарын нэг ажиллагчид ногдох ДНБ-ий хэмжээ 13.3 сая төгрөг буюу хамгийн өндөр түвшинд байсан байна.

1.6 БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

Манай улсад 2024 онд нийт 31.0 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн бөгөөд үүний 1.9 (6.1%) их наяд төгрөг нь барилгын салбарт хийгджээ. Барилгын салбарт хийгдсэн хөрөнгө оруулалт өмнөх оноос 421.5 (28.4%) тэрбум төгрөгөөр өссөн байна.


ЗУРАГ 6. БАРИЛГЫН САЛБАРЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, тэрбум төгрөгөөр



I.7 БАРИЛГЫН САЛБАРЫН ОСОЛ

Барилгын салбарт сүүлийн 5 жилд 209 хүн осолдсон бөгөөд үүний 11 (5.3%) нь эмэгтэйчүүд байна. Мөн сүүлийн 5 жилд үйлдвэрлэлийн ослын улмаас 55 хүн амь насаа алджээ.

ЗУРАГ 7. БАРИЛГЫН САЛБАРТ ОСОЛДСОН ХҮНИЙ ТОО



Улсын хэмжээнд сүүлийн 2024 онд 809 хүн осолдсоны 87 (10.8%) хүн амь насаа алдсан байна. Салбараар авч үзвэл уул уурхай, олборлох салбарт нийт 127 (15.7%) хүн, тээврийн салбарт 79 (9.8%) хүн, барилгын салбарт 67 (8.3%) хүн осолдсон байна.

ХҮСНЭГТ 2. ОСОЛДОГЧИД, салбараар, мянган хүн


Салбар	2020		2021		2022		2023		2024*	
	Осол-догчид	Нас барсан	Осол-догчид	Нас барсан	Осол-догчид	Нас барсан	Осол-догчид	Нас барсан	Осол-догчид	Нас барсан
Нийт	353	40	256	34	395	57	408	57	809	87
Барилга	43	10	21	6	50	15	28	7	67	17
Уул уурхай	73	7	34	11	84	13	103	15	127	13
Тээвэр	44	4	18	1	32	1	41	11	79	13

Эх үүсвэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, 2024 он



БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр



БАРИЛГЫН САЛБАРЫН АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ТОО




* Гэрийг оруулаагүй

II. БАРИЛГА УГСРАЛТ ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ


Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2024 онд 9.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 1.2 (14.8%) их наяд төгрөгөөр өссөн байна. Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийн 88.8 хувийг дотоодын, 11.2 хувийг гадаадын барилгын байгууллага гүйцэтгэсэн байна.

ЗУРАГ 8. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, тэрбум төгрөгөөр




Дотоодын барилгын байгууллагууд 2024 онд 8.1 их наяд төгрөгийн барилга угсралт, их засварын ажлыг гүйцэтгэсэн нь өмнөх оноос 733.3 (9.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

ЗУРАГ 9. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ХЭМЖЭЭ, улирлаар, тэрбум төгрөгөөр



Барилга угсралт, их засварын ажлын дийлэнх нь буюу 60.5 хувийг 2, 3-р улиралд хийж гүйцэтгэсэн байна.


ЗУРАГ 10. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, дүнд эзлэх хувь, 2024 он



Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн барилга угсралт, их засварын ажлын 98.2 хувийг хувийн байгууллага, 1.2 хувийг төрийн өмчийн байгууллага, 0.6 хувийг гадаадтай хамтарсан байгууллага гүйцэтгэсэн байна.


Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг барилгын төрлөөр авч үзвэл, орон сууцны барилга 35.7 хувийг, орон сууцны бус барилга 33.1 хувийг, инженерийн байгууламж 27.7 хувийг, их засварын ажил 3.5 хувийг эзэлж, өмнөх оноос орон сууцны барилгын эзлэх хувь 3.3 нэгж хувиар, орон сууцны бус барилгынх 2.1 нэгж хувиар, их засварын ажлынх 0.1 нэгж хувиар тус тус буурсан бол инженерийн барилга, байгууламжийн ажлын эзлэх хувь 5.5 нэгж хувиар өссөн байна.

ЗУРАГ 11. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр, дүнд эзлэх хувь



Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг бүсээр хувааж үзвэл, Улаанбаатар хот 48.5 хувь, Төвийн бүс 31.3 хувь, Хангайн бүс 8.6 хувь, Баруун бүс 6.2 хувь, Зүүн бүс 5.3 хувийг эзэлж, өмнөх оноос Төвийн бүсийн хотын барилга угсралт, их засварын ажлын эзлэх хувь 1.4 нэгж хувиар, Хангайн бүсийнх 1.3 нэгж хувиар, Зүүн бүсийнх 0.8 нэгж хувиар тус тус буурсан бол Улаанбаатар хотынх 2.4 нэгж хувиар, Баруун бүсийнх 1.1 нэгж хувиар өссөн байна.

ЗУРАГ 12. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, бүсээр, хувиар



2022 - 2024 онд баригдаж ашиглалтад орсон болон баригдаж буй томоохон барилга угсралт, их засварын ажлуудаас дурьдвал:

Улаанбаатар хотод:

- Багануур дүүрэг, 1-р хороо, 50 мВт батерей хуримтлуурын станцын ажил
- ХУД-ийн 20-р хороо, Мишээл лайф стайл үйлчилгээтэй конторын 20 давхар барилга
- БЗД, 11-р хороо, Гэр хорооллын дахин төлөвлөлтөөр хийгдэж буй орон сууц
- БЗД-ийн 1-р хороо, Сансарын Е-март худалдааны төвийн баруун талд "Сансар гарден" орон сууцны барилга
- ХУД-ийн 4-р хороо наадамчдын замын урд талд Хотын захиргааны шинэ байр Б блок

Орон нутагт:

- Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалтууд
- Дорноговь аймагт "Зүүнбаян-Ханги" чиглэлийн 226.9 км төмөр зам, "Шивэ хүрэн-Сэхэ" хил холболтын боомтын нарийн царигийн 19.3 км төмөр зам
- Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Завхан, Төв, Дундговь, Хэнтий, Говьсүмбэр, Сүхбаатар аймгуудын аймгийн дулааны цахилгаан станцын барилга
- Төв аймаг, Баянжаргалан сум, Бөөрөлжүүтийн цахилгаан станц-Блок-1
- Хэнтий аймгийн Өлзийт тосгонд MSC группын мал аж ахуй, газар тариалангийн фермэр

Авто замын ажил: Улсын хэмжээнд явагдаж буй авто замын барилгын томоохон ажлуудаас дурьдвал:

- Улаанбаатар - Дархан чиглэлийн 204.1 км хатуу хучилттай авто замын барилгын ажил
- Хэнтий аймгийн Өндөрхаан- Норовлин чиглэлийн 130 км хатуу хучилттай авто зам
- ХУД-ийн Наадамчдын авто замаас Энхтайвны өргөн чөлөө хүртэлх авто замын гүүрийн барилга
- СХД 20-р хороо, 5 шарын төмөр зам доогуурх нүхэн гарц
- Өвөрхангай аймаг Арвайхээр сум А0301 чиглэлийн Хүйтний хөндийгөөс Цагаан хаалга хүртэлх 57.6 км авто зам барих ажил

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН СУРГУУЛЬ, СОЁЛЫН БАЙГУУЛЛАГА,
мянган суудал



2023 он

2024 он

21.3

30.3

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ЭМНЭЛЭГ, орны тоо



1 211

1 104

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, мянган айл



19.2

19.8

АШИГЛАЛТАД ОРУУЛСАН АВТО ЗАМ, км




711.2

817.6

III. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД

Ашиглалтад оруулсан барилга угсралт, их засварын ажлын өртөг 2024 онд 8.5 их наяд төгрөгт хүрчээ. Нийт өртгийн 3.7 (44.0%) их наяд төгрөгийг бусад төрлийн барилга, 3.0 (35.0%) их наяд төгрөгийг орон сууцны барилга, 638.0 (7.5%) тэрбум төгрөгийг сургууль, соёлын барилга, 603.2 (7.1%) тэрбум төгрөгийг авто зам, 348.3 (4.1%) тэрбум төгрөгийг худалдаа, үйлчилгээний барилга, 120.0 (1.4%) тэрбум төгрөгийг гүүр, гүүрэн гарц, 72.5 (0.9%) тэрбум төгрөгийг эмнэлгийн барилга эзэлж байна.


ЗУРАГ 13. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД, барилгын төрлөөр, хувиар, 2024 он



III.1 АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА

Ашиглалтад оруулсан орон сууцны барилгын ажлын өртөг 2024 онд 3.0 их наяд төгрөг болж, өмнөх оноос 896.6 тэрбум төгрөгөөр өссөн байна. Нийт 19.8 мянган айлын орон сууцны барилгыг ашиглалтад оруулсан нь өмнөх оноос 594 айлаар өссөн байна.

ЗУРАГ 14. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, айлын тоо, өртгөөр




III.1.1 ИПОТЕКИЙН ЗЭЭЛ

Ипотекийн зээлд шинээр хамрагдсан иргэдийн тоо 2024 онд 21.2 мянга болж, өмнөх оноос 4.5 (26.6%) мянган иргэнээр өссөн байна.

2020 онд ипотекийн зээлийн хүүг 6.0 хувь болгон бууруулсан, 2021 онд “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 их наядын хөтөлбөр”-ийн хүрээнд санхүүжилтийн хэмжээ нэмэгдүүлсэн нь ипотекийн зээлийн олголт нэмэгдэх нөхцөл болсон хэдий ч, 2022 онд зээлийг хойшлуулж, зээлийн санхүүжилт тасалдсанаас хамааран зээлд шинээр хамрагдсан иргэдийн тоо буурсан байна. 2023 онд хөдөө орон нутагт болон Улаанбаатар хотын төвөөс алслагдсан Багануур, Багахангай, Налайх дүүрэгт орон сууц, амины орон сууц худалдан авах иргэдэд зориулан зээлийн хүүгийн болон барьцаа хөрөнгийн дэмжлэгтэй олгох орон сууц болон амины 3.0 хувийн орон сууцны ипотекийн зээл нэмэгдсэн зэрэг нь ипотекийн зээлд хамрагдсан иргэдийн тоо өсөхөд нөлөөлжээ.

Ипотекийн зээлийн нийт үлдэгдэл 2024 онд 9.4 их наяд төгрөгт хүрч, зээлдэгчийн тоо 123.0 мянга болсон байна.


ЗУРАГ 15. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БАРИЛГА, ИПОТЕКИЙН ЗЭЭЛД ХАМРАГДСАН ИРГЭДИЙН ТОО



Эх үүсвэр: Монголын ипотекийн корпорацын 2024 оны тайлан

Улсын хэмжээнд 19.8 мянган айлын орон сууц ашиглалтад орсны 15.0 (75.5%) мянга нь Улаанбаатар хотод, 4.8 (24.5%) мянга нь орон нутагт байна.

ЗУРАГ 16. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦ, айлын тоогоор, аймгаар



III.2 АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ОРОН СУУЦНЫ БУС БАРИЛГА

Сургууль, соёлын барилга: Улсын хэмжээнд 2024 онд 30.3 мянган суудалтай сургууль, соёлын барилга ашиглалтад оруулсан бөгөөд үүний 12.2 (40.4%) мянга нь Улаанбаатар хотод, 18.1 (59.6%) мянга нь аймгуудад байна.

ЗУРАГ 17. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН СУРГУУЛЬ, СОЁЛЫН БАРИЛГА, суудлаар



Дархан-Уул аймагт 3480 суудалтай сургууль, соёлын барилга ашиглалтад оруулсан нь аймгуудын хэмжээнд хамгийн их, Сэлэнгэ аймагт 200 суудалтай сургууль, соёлын барилга ашиглалтад оруулсан нь хамгийн бага үзүүлэлт болж байна.

Эмнэлгийн барилга: Улсын хэмжээнд нийт 1104 ортой эмнэлгийн барилга ашиглалтад оруулсан боловч орны тоо өмнөх оноос 107 (8.8%) -оор буурсан байна.

ЗУРАГ 18. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ЭМНЭЛЭГ, орны тоогоор



Тухайлбал: Дорнод аймагт 405 ортой, Улаанбаатар хотод 286 ортой, Дархан-Уул аймагт 118 ортой, Хэнтий аймагт 70 ортой эмнэлгийн барилгууд ашиглалтад орсон байна.

III.3 МОНГОЛ УЛСЫН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭ

Монгол Улсын авто замын сүлжээний нийт урт 2024 онд 111.9 мянган км байгаа бөгөөд үүнээс олон улс, улсын чанартай 15.0 мянган км авто зам, орон нутгийн чанартай 96.0 мянган км авто зам, тусгай зориулалтын 966.0 км авто зам байна.²

Улсын чанартай 15.0 мянган км авто замыг төрлөөр нь авч үзвэл, хатуу хучилттай авто зам 7.9 (52.7%) мянган км, ердийн хөрсөн зам 5.7 (38.2%) мянган км, сайжруулсан хөрсөн зам 310.1 (2.1%) км, хайрган хучилттай зам 1.1 (7.0%) мянган км байна. Хатуу хучилттай замаас 7.9 (99.7%) мянган км нь асфальт бетон, 24.8 (0.3%) км нь цемент бетон авто зам байна.²

ХҮСНЭГТ 3. МОНГОЛ УЛСЫН АВТО ЗАМЫН СҮЛЖЭЭ, ангиллаар

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
	км				
Авто замын сүлжээний нийт урт	111 916.7	111 916.7	111 916.7	111 916.7	111 916.7
Ердийн хөрсөн зам	99 952.9	99 891.2	100 354.7	99 758.3	99 077.4
Сайжруулсан хөрсөн	604.9	604.9	697.7	740.3	703.1
Хайрган хучилттай	1 207.9	1 176.8	920.5	1 111.1	1 305.7
Хатуу хучилттай	10 151.0	10 243.8	9 943.7	10 307.0	10 830.5
Улсын чанартай авто зам	14 893.0	14 918.7	14 918.7	14 920.9	14 960.1
Ердийн хөрсөн зам	6 074.8	6 038.8	6 603.1	6 182.3	5 711.9
Сайжруулсан хөрсөн	211.9	211.9	304.7	347.3	310.1
Хайрган хучилттай	923.6	921.4	665.1	855.7	1 050.3
Хатуу хучилттай	7 682.7	7 746.6	7 345.7	7 535.6	7 887.8
Орон нутгийн чанартай	96 125.3	96 099.6	96 099.6	96 040.0	95 990.6
Ердийн хөрсөн зам	93 878.1	93 852.4	93 751.6	93 576.0	93 365.5
Сайжруулсан хөрсөн	393.0	393.0	393.0	393.0	393.0
Хайрган хучилттай	284.3	255.4	255.4	255.4	255.4
Хатуу хучилттай	1 569.9	1 598.8	1 699.6	1 815.6	1 976.7
Тусгай зориулалтын	898.4	898.4	898.4	955.8	966.0
Хатуу хучилттай	898.4	898.4	898.4	955.8	966.0

ЗУРАГ 19. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН АВТО ЗАМ, км



Улсын хэмжээнд нийт 817.6 км авто замыг шинээр ашиглалтад оруулсан бөгөөд энэ нь 2023 оноос 106.4 (15.0%) км-ээр нэмэгдсэн байна. Хэнтий аймагт 200.6 км авто зам ашиглалтад оруулсан нь улсын хэмжээнд ашиглалтад оруулсан нийт автозамын 24.5 хувийг эзэлж байна.

² Зам тээвэр, хөгжлийн яамны 2024 оны статистик тайлан

Улсын хэмжээнд 2024 онд 3361.6 метр гүүр, гүүрэн гарцыг шинээр ашиглалтад оруулсан нь өмнөх оноос 1634.6 (94.6%) метрээр нэмэгдсэн байна. Улаанбаатар хотод 3104.9 метр гүүр, гүүрэн гарц ашиглалтад оруулжээ.

ЗУРАГ 20. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ГҮҮР, ГҮҮРЭН ГАРЦ, метр

Тухайлбал: 2024 онд ХУД-т Наадамчдын авто замаас Энхтайвны өргөн чөлөө хүртэлх авто замын гүүрийн барилга / Шинэ яармагын гүүр/, СХД-т 5 шарын төмөр зам доогуурх нүхэн гарцын ажлуудыг ашиглалтад оруулжээ.

БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН
БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ, 2024 он

ҮЙЛДВЭРЛЭЛ

16.6




Зүсмэл модон матеиал мян.м³

ИМПОРТ

51.2

1 894.7



Цемент мян.тонн

256.3

59.1 мян.тн



Шохой

163.5 м³

ҮЙЛДВЭРЛЭЛ




Хөнгөн бетон, мян.м³

30.3

Хөөсөнцөр хавтан, мян.м³

50.7

ИМПОРТ



Арматур, Катанка, мян.тн

356.4

Ширмэн радиатор, мян.м³

3 312.9


IV. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

IV.1 ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ

Манай улс 2024 онд 16.6 мян.м³ барилгын зүсмэл модон материал, 1.9 сая.тн цемент, 59.1 мян.тн шохой, 30.3 мян.м³ хөнгөн бетон, 50.7 мян.м³ хөөсөнцөр хавтан үйлдвэрлэсэн байна. Харин 51.2 мян.м³ барилгын зүсмэл модон материал, 256.3 мян.тн цемент, 163.5 кг шохой, 356.4 мян.тн арматур, катанка, 3.3 мянган.тн ширмэн радиатор импортолсон байна.


Цементийн үйлдвэрлэл өмнөх оноос 181.0 тн буюу 10.6 хувиар, импорт 1.3 мян.тн буюу 0.5 хувиар нэмэгдсэн байна.

ЗУРАГ 21. ЦЕМЕНТИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ, МЯН.ТН




Блок үйлдвэрлэл 2024 онд 335.5 мян.тн, импорт 13.4 мян.тн болж, үйлдвэрлэл өмнөх оноос 161.6 мян.тн буюу 92.9 хувиар, импорт 1.2 мян.тн буюу 9.9 хувиар тус тус нэмэгдсэн байна.

ЗУРАГ 22. БАРИЛГЫН БЛОКИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ИМПОРТ, МЯН.ТН



Барилгын зарим нэр төрлийн бүтээгдэхүүний 2024 оны үйлдвэрлэлийг гол нэр төрлөөр авч үзвэл, цементийн үйлдвэрлэл 1894.7 мян.тн, бетон зуурмагийн үйлдвэрлэл 903.9 мян.м3, шохойн үйлдвэрлэл 59.1 мян.тн болж өмнөх оноос цементийн үйлдвэрлэл 181.0 (10.6%) мян.тн-оор, бетон зуурмагийн үйлдвэрлэл 164.8 (22.3%) мян.м3, шохойн үйлдвэрлэл 0.3 (0.6%) мян.тн-оор тус тус өссөн байна.

ЗУРАГ 23. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ³



Мөн хүрмэн блок 37.0 мянган ширхэг, суурийн блок 335.5 мян.м³, хөнгөн бетон 30.3 мян.м³, улаан тоосго 16.2 сая ширхэг, хөөсөндөр хавтан 50.7 мян.м³ тус тус үйлдвэрлэжээ.

IV.2 ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ⁴

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮНЭ, төгрөг


Тоосго, ширхэг 396		Цемент, 50кг 22 185
Ханын цаас, боодол 24 640		Плита, ширхэг 5 000
	Вакум цонх, метр кв 213 189	

³ Аж үйлдвэрийн статистикийн 2024 оны мэдээ

⁴ Үнийн статистикийн 2024 оны мэдээ

Барилга угсралтын ажилд түгээмэл хэрэглэгддэг зарим нэр төрлийн бүтээгдэхүүний зах зээлийн жилийн дундаж үнийг авч үзэхэд ханын цаас 24640 төгрөг, цагаан тосон будаг 6604 төгрөг, плита 5000 төгрөг, цемент 22185 төгрөгт, тоосго 396 төгрөг, вакум цонх 213.2 мянган төгрөгт хүрч, өмнөх онтой харьцуулж үзвэл, вакум цонхны үнэ 10 (5.1%) мянган төгрөгөөр, цемент 752 (3.5%) төгрөгөөр, цагаан тосон будаг 631 (10.6%) төгрөгөөр, плита 352 (7.6%) төгрөгөөр өссөн бол ханын цаас 231 (0.9%) төгрөгөөр, тоосго 9 (2.3%) төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 24. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ЖИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ



Эх үүсвэр: Үнийн статистикийн 2024 оны мэдээ

V. БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС


Барилгын өртгийн ерөнхий индекс (2015=100) 2024 оны 4 дүгээр улиралд 262.3 болж, барилгын өртөг өмнөх оны мөн үеэс 13.4 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.7 нэгж хувиар өссөн байна.

Орон сууцны барилгын өртгийн индекс (2015=100) 2024 оны 4 дүгээр улиралд 315.0 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 24.1 нэгж хувиар өссөн бол өмнөх улирлаас 1.1 нэгж хувиар буурсан байна.

Орон сууцны бус барилгын өртгийн индекс (2015=100) 2024 оны 4 дүгээр улиралд 254.4 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 10.8 нэгж хувиар, өмнөх улирлаас 1.2 нэгж хувиар өссөн байна.

Инженерийн барилга, байгууламжийн өртгийн индекс (2015=100) 2024 оны 4 дүгээр улиралд 176.5 болж, өртөг нь өмнөх оны мөн үеэс 11.0 нэгж хувиар, өмнөх улирлаас 0.6 нэгж хувиар өссөн байна.

ЗУРАГ 25. БАРИЛГЫН ӨРТГИЙН ИНДЕКС (2015=100), улирлаар, хувиар



VI. ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС

Орон сууцны үнийн мэдээллийг зар мэдээллийн сангаас шүүх аргаар цуглуулж, Улаанбаатар хотын төвийн 6 дүүргийн мэдээллийг ашиглан орон сууцны үнийн индексийг тооцдог.

Орон сууцны үнийн индекс (2023.I=1.0) 2024 оны эцэст 1.23 болж, өмнөх оноос 14.6 хувиар өссөн байна.

Орон сууцны насжилтаар авч үзвэл шинэ орон сууцны үнэ өмнөх оноос 12.6 хувиар, хуучин орон сууцны үнэ 16.0 хувиар тус тус өссөн байна.

ХҮСНЭГТ 4. ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	<u>2024</u> <u>2023</u>
	2023.I=1				хувь
Нийт орон сууц	0.87	0.99	1.08	1.23	14.6
Шинэ орон сууц	0.81	1.00	1.10	1.24	12.6
Хуучин орон сууц	0.89	0.99	1.05	1.22	16.0

2024 оны эцэст шинэ орон сууцны 1 метр квадрат талбайн дундаж үнэ 4653 мянган төгрөг болж, Сүхбаатар дүүрэгт хамгийн өндөр буюу 5716 мянган төгрөгийн үнэтэй байна.

Шинэ орон сууцны дундаж үнэ өмнөх оны мөн үетэй харьцуулахад Чингэлтэй дүүрэгт 33.2 хувь (1150.4 мянган төгрөг)-аар өссөн нь хамгийн өндөр, Хан-Уул дүүрэгт 10.3 хувь (438.0 мянган төгрөг)-аар өссөн нь хамгийн бага байна.

2024 оны эцэст хуучин орон сууцны 1 метр квадрат талбайн дундаж үнэ 4266 мянган төгрөг болж, Сүхбаатар дүүрэгт хамгийн өндөр буюу 5899 мянган төгрөгийн үнэтэй байна.

Хуучин орон сууцны хувьд Сүхбаатар дүүрэгт 36.9 хувь (1589.7 мянган төгрөг)-аар өссөн нь хамгийн өндөр, Баянзүрх дүүрэгт 12.0 хувь (409.4 мянган төгрөг)-аар өссөн нь хамгийн бага байна.

ЗУРАГ 26. ОРОН СУУЦНЫ 1 МЕТР КВАДРАТ ТАЛБАЙН ДУНДАЖ ҮНЭ, мянган төгрөгөөр



Шинэ болон хуучин орон сууцны 1 метр квадрат талбайн дундаж үнэ Сүхбаатар дүүрэгт 5715.7-5899.2 мянган төгрөг, Чингэлтэй дүүрэгт 4616.7-4684.8 мянган төгрөг, Хан-Уул дүүрэгт 4567.9-4678.0 мянган төгрөг байгаа нь орон сууцны байршил үнэд чухал нөлөөтэйг харуулж байна.

ХҮСНЭГТ 5. ОРОН СУУЦНЫ 1 МЕТР КВАДРАТ ТАЛБАЙН ДУНДАЖ ҮНЭ, оны эцэст

Дүүрэг	2021	2022	2023	2024 2023	
	мянган төгрөг			Дүн	хувь
Шинэ орон сууцны дундаж үнэ					
Баянгол	3198.2	3834.2	4284.1	449.9	11.7
Баянзүрх	2977.6	3634.0	4450.3	816.2	22.5
Сонгинохайрхан	2404.4	2684.7	3292.1	607.5	22.6
Сүхбаатар	4266.8	4319.2	5715.7	1396.4	32.3
Хан-Уул	3666.3	4240.0	4678.0	438.0	10.3
Чингэлтэй	3191.0	3466.3	4616.7	1150.4	33.2
Баянгол	3198.2	3834.2	4284.1	449.9	11.7
Хуучин орон сууцны дундаж үнэ					
Баянгол	2968.6	3085.7	3758.1	672.4	21.8
Баянзүрх	3072.3	3404.7	3814.1	409.4	12.0
Сонгинохайрхан	2511.1	2588.2	2938.0	349.8	13.5
Сүхбаатар	3933.3	4309.5	5899.2	1589.7	36.9
Хан-Уул	3524.7	3908.4	4567.9	659.4	16.9
Чингэлтэй	3538.6	3940.1	4684.8	744.7	18.9
Баянгол	2968.6	3085.7	3758.1	672.4	21.8

VII. ДҮГНЭЛТ

Барилгын салбарын ДНБ-д эзлэх хувь 2024 онд 3.7 хувь болжээ. Мөн тус салбарт бүртгэлтэй 18.3 мянган аж ахуйн нэгж байгаагийн 8.6 мянга буюу 46.9 хувь нь үйл ажиллагаа явуулж байна.

Барилгын салбарын ажиллагчдын тоо 93.2 мянгад хүрч өмнөх оноос 11.1 мянга буюу 13.5 хувиар өссөн байна. Тус салбарын ажиллагчдын сарын дундаж цалин 2166.0 мянган төгрөг байгаа нь улсын дунджаас 7.1 хувиар бага байна.

Барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэл 2024 онд 9.2 их наяд төгрөгт хүрч, үүний 35.7 хувийг орон сууцны барилга, 33.1 хувийг орон сууцны бус барилга, 27.7 хувийг инженерийн барилга байгууламж, 3.5 хувийг их засварын ажил тус тус эзэлж байна.

Улсын хэмжээнд 2024 онд 19.8 мянган айл бүхий орон сууцны барилга, 817.6 км урт авто зам, 30.3 мянган суудал бүхий сургууль, соёлын барилга, 1104 ор бүхий эмнэлгийн барилга тус тус баригдаж ашиглалтад оруулсан байна.

2013 оноос төрөөс хэрэгжүүлж эхэлсэн ипотекийн жилийн 8 хувийн хүүтэй орон сууцны зээл нь иргэдийн амьжиргаанд үр өгөөжийг өгсөн. 2024 онд ипотекийн зээлд нийт 123.0 мянган иргэн хамрагдаж, өөрийн эзэмшлийн орон сууцтай болсон байна.

Сүүлийн жилүүдэд барилга угсралтын ажил эрчимтэй өрнөж байгаагийн дийлэнх нь нийслэл Улаанбаатар хотод явагдаж байгаа бөгөөд үүнийг даган энгийн орон сууцаас гадна чинээлэг хэрэглэгчдэд зориулсан, тэдний хэрэгцээ шаардлагыг хангах тансаг зэрэглэлийн орон сууцууд олноор баригдаж байна. Мөн орон сууцны бус барилга, ялангуяа худалдаа, үйлчилгээний барилга угсралтын ажил эрчимтэй нэмэгдэж байгаа нь барилга угсралтын ажлын бүтцээс харагдаж байна.

Түүнчлэн Оюутолгойн далд уурхайн бүтээн байгуулалт, Өмнөговь, Дорноговь аймагт “Зүүнбаян-Ханги” чиглэлийн 226.9 км төмөр зам, “Шивэ хүрэн-Сэхэ” хил холболтын боомтын нарийн царигийн 19.3 км төмөр замын ажлыг ашиглалтад оруулсан байна. Баянхонгор, Өвөрхангай, Говь-Алтай, Завхан, Төв, Дундговь, Хэнтий, Говьсүмбэр, Сүхбаатар аймгуудын дулааны цахилгаан станцын барилгын ажлууд, Төв аймагт “Бөөрөлжүүтийн цахилгаан станц” Дархан-Улаанбаатар чиглэлийн авто замын ажлууд барилгын салбарын үйлдвэрлэлд томоохон хувь нэмэр оруулсан байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Барилга байгууламж, объектын улирлын мэдээ, ҮСХ
- Хэрэглээний үнийн сарын мэдээ, 2024 , ҮСХ
- Орон сууцны үнийн индекс, 2024, ҮСХ
- Аж үйлдвэрийн салбарын мэдээ, 2024, ҮСХ
- Тээврийн салбарын танилцуулга, 2024, ҮСХ
- Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2024, ҮСХ
- Гадаад худалдааны салбарын статистикийн мэдээ – 2024, ҮСХ
- Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам / www.mcud.gov.mn /
- Монголын Ипотекийн Корпорацын жилийн тайлан, 2024, МИК /www.mik.mn/
- Монгол банкны цахим сан /www.mongolbank.mn/
- Статистик мэдээллийн нэгдсэн сан /www.1212.mn/
- Зам тээвэр хөжлийн яамны цахим сан /www.mrtd.gov.mn/

ХАВСРАЛТ ХҮСНЭГТҮҮД

ХҮСНЭГТ 1. БАРИЛГЫН САЛБАРЫН ААНБ-ЫН ТОО

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Бүртгэлтэй ААНБ	15 858	17 522	18 616	17 135	18 279
Үйл ажиллагаа явуулж байгаа ААНБ	6 258	6 675	7 684	8 297	8 565

Эх үүсвэр: Статистикийн бизнес регистрийн сан, ҮСХ

ХҮСНЭГТ 2. АЖИЛЛАГЧДЫН ТОО

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
15 ба түүнээс насны ажиллагчдын тоо	1 249 643	1 207 991	1 283 128	1 294 746	1 355 667
Барилгын салбарт ажиллагчдын тоо	80 405	87 810	82 539	82 077	93 165

Эх үүсвэр: Ажиллах хүчний судалгаа, ҮСХ

ХҮСНЭГТ 3. БАРИЛГЫН САЛБАРЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ОСОЛ, хүйсээр, ослын хэлбэрээр

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024
Осолдогчид	43	21	50	28	67
Нас барсан	10	6	15	7	17
Үүнээс: Эмэгтэй	2	0	2	2	5

Эх үүсвэр: ХНХЯ-ны мэдээлэл

ХҮСНЭГТ 4. БАРИЛГЫН САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024*
	тэрбум төгрөг				
Тайлант оны үнээр	1 367.5	1 368.8	1 783.8	2 269.8	2 605.6
2015 оны зэрэгцүүлэх үнээр	1 070.0	825.5	893.0	921.0	1 017.0

ХҮСНЭГТ 5. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, дотоод, гадаадын байгууллагаар

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024*
	тэрбум төгрөг				
Барилга угсралт, их засварын ажил	5 438.7	5 087.9	6 758.7	7 977.9	9 158.4
Дотоодын барилгын байгууллагын гүйцэтгэсэн	5 187.9	4 550.7	6 304.4	7 402.6	8 136.0
Гадаадтай хамтарсан байгууллагын гүйцэтгэсэн	78.3	49.1	47.2	60.3	50.7
Гадаадын байгууллагын гүйцэтгэсэн	250.8	537.2	454.4	575.3	1 022.5

ХҮСНЭГТ 6. БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖЛЫН БҮТЭЦ, барилгын төрлөөр

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024*
	Дүнд эзлэх хувь				
Барилга угсралт, их засварын ажил-бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0
Орон сууцны барилга	33.8	33.9	37.2	38.9	35.7
Орон сууцны бус барилга	32.7	34.9	30.5	35.2	33.1
Үйлдвэрийн	13.1	20.6	14.6	14.8	12.3
Худалдаа, үйлчилгээний	2.7	2.5	2.9	3.9	4.1
Эмнэлэг, сургууль, соёлын	11.1	7.8	7.3	9.9	8.9
Бусад	5.9	4.1	5.7	6.6	7.8
Инженерийн байгууламж	30.8	28.7	29.5	22.2	27.7
Эрчим хүчний	1.0	0.5	1.8	4.1	7.6
Холбооны	0.0	0.0	0.0	0.3	0.4
Төмөр зам	15.5	16.8	19.0	4.9	3.5
Авто зам	7.9	5.6	4.3	6.9	7.1
Гүүр, гүүрэн гарц	0.3	0.4	0.5	0.8	1.3
Далан, суваг, шугам, сүлжээ	4.7	4.2	2.5	3.0	6.0
Бусад(зам, талбайн бусад ажил)	1.5	1.1	1.4	2.3	1.8
Их засварын ажил	2.7	2.5	2.9	3.6	3.5

ХҮСНЭГТ 7. ДОТООДЫН БАРИЛГЫН БАЙГУУЛЛАГЫН ГҮЙЦЭТГЭСЭН БАРИЛГА УГСРАЛТ, ИХ ЗАСВАРЫН АЖИЛ, бүс, аймаг, нийслэлээр

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024*
	тэрбум төгрөг				
Бүгд	5 187.9	4 550.7	6 304.4	7 402.6	8 136.0
Баруун бүс	291.7	220.7	219.5	384.2	568.9
Баян-Өлгий	33.5	27.4	48.8	98.1	117.8
Говь-Алтай	121.9	25.0	42.5	39.4	82.1
Завхан	36.7	22.3	33.2	91.0	147.2
Увс	53.3	26.5	17.9	90.2	113.5
Ховд	46.2	119.4	77.1	65.5	108.3
Хангайн бүс	323.7	331.9	426.5	765.5	786.8
Архангай	60.8	41.4	49.2	145.1	98.9
Баянхонгор	34.8	31.6	35.5	84.8	66.3
Булган	18.5	12.5	31.9	87.0	99.5
Орхон	121.0	130.6	172.2	224.2	274.4
Өвөрхангай	53.0	61.1	67.4	113.2	128.2
Хөвсгөл	35.6	54.8	70.2	111.1	119.6
Төвийн бүс	1 981.6	1 846.6	2 548.2	2 219.2	2 473.2
Говьсүмбэр	8.0	4.6	21.8	18.4	38.1
Дархан-Уул	95.7	92.7	154.9	293.5	471.1
Дорноговь	537.3	284.2	1 349.7	387.1	298.5
Дундговь	25.7	32.7	46.7	70.7	68.0
Өмнөговь	1 118.0	1 369.7	883.4	1 265.6	1 293.4
Сэлэнгэ	68.5	25.8	53.4	77.1	192.4
Төв	128.5	36.9	38.3	106.8	111.7
Зүүн бүс	181.7	176.5	240.0	460.4	470.0
Дорнод	27.7	54.5	96.1	121.4	137.1
Сүхбаатар	33.5	25.5	32.7	71.2	50.1
Хэнтий	120.5	96.5	111.2	267.8	282.9
Улаанбаатар	2 409.3	1 974.8	2 870.2	3 573.3	3 837.1

ХҮСНЭГТ 8. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ФОНД, барилгын төрлөөр

Үзүүлэлт	2020	2021	2022	2023	2024*
	тэрбум.төг				
Бүгд	2 762.4	2 706.5	5 858.4	4 438.4	8 492.5
Орон сууцны	1 070.7	1 576.3	2 141.8	2 077.8	2 974.4
Худалдаа, үйлчилгээний барилга	80.8	139.2	129.8	213.5	348.3
Эмнэлгийн	119.9	33.5	52.9	99.5	72.5
Сургууль, соёлын	413.1	321.8	286.1	443.6	638.0
Авто зам	315.0	166.3	484.1	249.8	603.2
Гүүр, гүүрэн гарц	84.0	58.8	19.4	167.0	120.0
Бусад	678.9	410.6	2 744.3	1 187.2	3 736.0

ХҮСНЭГТ 9. АШИГЛАЛТАД ОРУУЛСАН ҮНДСЭН ХӨРӨНГӨ, барилгын төрөл, хүчин чадлаар

Он	2020	2021	2022	2023	2024*
Орон сууцны барилга, айлын тоо	14 165	17 478	23 201	19 196	19 790
Эмнэлэг, орны тоо	1 379	505	1 225	1 211	1 104
Сургууль, соёлын барилга, суудлын тоо	48 946	27 839	28 226	21 316	30 309
Авто зам, км	410.3	213.5	545.2	711.2	817.6
Гүүр, гүүрэн гарц, метр	789.3	1 513.5	1 692.1	1 727.0	3 361.6

ХҮСНЭГТ 10. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛ

Он	Цемент, мян.тонн	Бетон зуурмаг мян.м ³	Шохой мян.тонн	Хөнгөн бетон, мян.м ³	Суурийн блок мян.м ³	Хүрмэн блок мян.ш	Улаан тоосго мян.ш	Хөөсөнцөр хавтан, мян.м ³
2020	1 182.2	274.2	70.2	7.0	207.6	111.8	19 912.1	33.2
2021	1 293.3	607.9	50.7	19.8	195.1	291.3	20 394.9	37.4
2022	1 373.5	834.4	66.5	11.7	244.3	202.3	23 407.4	20.3
2023	1 713.6	739.1	58.8	12.6	173.9	56.9	23 307.0	60.3
2024*	1 894.7	903.9	59.1	30.3	335.5	37.0	16 160.3	50.7

Эх үүсвэр: Аж үйлдвэрийн салбарын танилцуулга - 2024, ҮСХ

ХҮСНЭГТ 11. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ИМПОРТ

Он	Цемент, мян.тонн	Цонхны шил, мян.м ²	Ширмэн радиатор, тонн	Арматур, катанка, мян.тонн	Галт тэсвэртэй тоосго, блок, хавтан, тонн	Хар цаас, тонн	Зүсмэл модон материал /Банз/ мян.м ³	Барилгын блок, м ³
2020	315.9	4 433.2	1 595.1	238.9	1 301.3	26 383.5	1 949.7	2 550.5
2021	4.8	1 777.5	2 018.5	260.8	2 755.1	22 157.1	2 717.0	1 772.3
2022	53.1	42.5	4 360.3	334.4	15 898.3	17 175.9	3 107.0	18.5
2023	255.0	15.0	7 855.8	288.9	18 986.5	16 237.0	3 215.1	12 202.2
2024	256.3	12.5	3 312.9	356.4	14 642.3	23 791.5	51 213.8	13 411.7

Эх үүсвэр: ГЕГ-ын импортын мэдээлэл

ХҮСНЭГТ 12. БАРИЛГЫН ЗАРИМ НЭР ТӨРЛИЙН БАРААНЫ ЖИЛИЙН ДУНДАЖ ҮНЭ

Материалын нэр	2020	2021	2022	2023	2024	2024% 2023
	төгрөгөөр					
Ханын цаас, боодол, БНСУ	13 198	20 994	25 647	24 872	24 640	-0.9
Цагаан тосон будаг, 1 литр, БНХАУ	4 253	4 042	5 148	5 972	6 604	10.6
Плита, ширхэг, БНХАУ	2 169	2 275	3 872	4 648	5 000	7.6
Цемент, 50 кг, БНХАУ	12 066	13 383	18 878	21 433	22 185	3.5
Тоосго, ширхэг, дотоодын	338	345	447	405	396	-2.3
Вакум цонх, 1 м2	100 908	112 851	159 317	202 748	213 189	5.1

Эх үүсвэр: Хэрэглээний үнийн сарын мэдээ, ҮСХ